

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн  
5. дугаар тогтоолын Хэвсрэлт 3



## **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү Иншүрко даатгал ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах журам (цаашид "Журам" гэх)-аар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулах, хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "Хороо" гэх) болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Журам нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс, Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам, холбогдох бусад хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.

### **ХОЁР. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ**

2.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

2.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

2.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор буюу 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор зарлан хуралдуулна.

2.4. Компанийн тухай хуульд заасан хурал зарлах эрх бүхий этгээд шаардлагатай тохиолдолд компанийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.

### **ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАХ**

3.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл эсхүл Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.7 дахь хэсэгт заасан этгээд гаргана.

3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:

3.2.1. Хурал хуралдуулах газар, өдөр болон цаг;

3.2.2. Хурлаар хэлэлцэх асуудал;

3.2.3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

- 3.2.4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;
- 3.2.5. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг, баримтын жагсаалт;
- 3.2.6. Саналын хуудсаар санал авах тохиолдолд санал авах хуудасны агуулга;
- 3.2.7. Санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр, хүлээн авах газар;
- 3.2.8. Хурлын дарга;
- 3.2.9. Тооллогын комиссын дарга, гишүүд.

3.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт заасан шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулна.

3.4. Компани Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт заасан шийдвэр гарснаас хойш 5 (тав) хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэнэ.

#### **ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ**

4.1. Дараах тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна. Үүнд:

- 4.1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
- 4.1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;
- 4.1.3. Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
- 4.1.4. Компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;
- 4.1.5. Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан;
- 4.1.6. Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
- 4.1.7. Компанийн дүрэмд заасан бусад тохиолдол.

4.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь ээлжит бус хурлыг хуралдуулах тухай санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор хурал хуралдуулах эсэх талаар шийдвэр гаргана.

4.3. Гагцхүү дараах тохиолдолд ээлжит бус хурлыг хуралдуулахаас татгалзах шийдвэр гаргах бөгөөд энэ шийдвэр, татгалзсан үндэслэлийн талаар шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчид даруй мэдэгдэнэ. Үүнд:

4.3.1. Ээлжит бус хурал хуралдуулах тухай шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчдийн саналын эрх нь нийт саналын эрхийн 10 хувьд хүрээгүй;

4.3.2. Ээлжит бус хурлаар хэлэлцэхээр санал болгож байгаа асуудал нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй.

4.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай санал шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргаагүй тохиолдолд санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргаж болно.

4.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасан тохиолдолд санал, шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор хурлыг хуралдуулна.

#### **ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХ**

5.1. Доор дурдсан асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

5.1.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;

5.1.2. Нийлүүлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

5.1.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

5.1.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх;

5.1.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

5.1.6. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;

5.1.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

5.1.8. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ эдлэх эсэх;

5.1.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

5.1.10. Төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;

- 5.1.11. Төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- 5.1.12. Компанийн тухай хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх ;
- 5.1.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- 5.1.14. Компанийн тухай хуулийн 96.4 заасан тайлан;
- 5.1.15. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд;
- 5.1.16. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудлууд.

### **ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

- 6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд компанийн энгийн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгнө.
- 6.2. Компанийн нэг хувьцаа саналын нэг эрхтэй байна.
- 6.3. Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид нь санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр санал өгөх эрхтэй.
- 6.4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоос бусад асуудлыг хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ.
- 6.5. Дараах асуудлуудыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.
  - 6.5.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;
  - 6.5.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
  - 6.5.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
  - 6.5.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
  - 6.5.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
  - 6.5.6. Хувьцааг хуваах буюу нэгтгэх.

## **ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД ОРОЛЦОХ ЭРХ**

7.1. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээд гарган хурал зарласан этгээдэд хүргүүлнэ.

7.2. Бүртгэлийн өдрийг Төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь Журмын 8.4-т заасны дагуу хурал хуралдуулах тухай зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15-20 дахь өдөр байна.

7.3. Бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр болон хувьцаа эзэмшигчдийн хурлын зард заана.

7.4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь хуралд оролцоно.

7.5. Компани нь хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг компанийн энгийн хувьцааны 10 ба түүнээс дээш хувийг эзэмшигч этгээдэд шаардсан тохиолдолд танилцуулна.

7.6. Төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээдийн бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

### **НАЙМ. ХУРЛЫН ЗАРЫГ ХҮРГЭХ**

8.1. Хурал зарлагч этгээд Хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор Хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлнэ.

8.2. Журмын 8.1-д заасан Хурлын мэдэгдэлд дараах баримт, материалыг хавсаргана. Үүнд:

8.2.1. хурал хуралдуулах тухай шийдвэр;

8.2.2. хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар;

8.2.3. хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа;

8.2.4. хурал хуралдуулах шийдвэр гаргасан ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд тусгагдсан хуралд оролцсон гишүүд, хурлаар хэлэлцсэн асуудал, санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн, гаргасан шийдвэр зэргийн баримт материал;

8.2.5. саналын эрх бүхий энгийн хувьцааны буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон төлөөлөн удирдах зөвлөл, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүн /компанийн дүрэмд хурлаар хэлэлцэхээр заасан бол/-ий талаар хурлын хэлэлцэх асуудалд санал оруулсан түүний хуулбар

8.3. ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, эсхүл Компанийн саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч нь Журмын 4.1-т заасан үндэслэлээр хурал зарласан бол хурлын мэдэгдэлд тус Журмын 8.2-т зааснаас гадна дараах баримт, материалыг хавсаргана. Үүнд:

8.3.1. ТУЗ-д санал шаардлага хүргүүлснийг нотлох баримт /албан бичгийн хуулбар, түүнийг хүлээн авсан ТУЗ-ийн даргын гарын үсэг, санал шаардлагад өгсөн ТУЗ-ийн хариу, хариу өгөөгүй тохиолдолд хурал зарлаж буй хувьцаа эзэмшигчийн тайлбар/;

8.3.2. Саналын эрх бүхий хувьцааны 10 ба түүнээс дээш хувийг эзэмшиж буйг батлах хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээдийн тодорхойлолт.

8.4. Компанийн тухай хуулийн 60.4-т заасны дагуу хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг гарснаас хойш 5 хоногийн дотор хурлын зарыг Журмын 4.1-т заасны дагуу нийтэд мэдээлнэ.

8.5. Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг хурал хуралдахаас 30 болон түүнээс багагүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан хоёр ба түүнээс дээш удаа хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлнэ.

8.6. Энэ журмын 8.4-т заасан мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлнэ.

8.7. Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг Журмын 8.5-д зааснаас гадна утас, факс, электрон шуудан зэрэг холбоо харилцааны боломжит бусад хэрэгслийг ашиглан хувьцаа эзэмшигчдэд хүргэж болно.

8.8. Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдөр гэдгийг арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар нийтэд хүргэсэн өдрийг тооцно.

8.9. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан хурлын ирц хүрээгүй тохиолдолд энэ тухай тэмдэглэл, протокол үйлдэж, хойшлогдсон хурлын товыг тогтоож, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гарган хурлыг хойшлуулна. Хурал хойшлогдсон тухай мэдэгдлийг холбогдох материалын хамт Хороо, арилжаа эрхлэх байгууллагад ажлын 4 өдөрт багтаан тус тус ирүүлнэ.

8.10. Хойшлогдсон хурлыг Компанийн тухай хуулийн 69.6-д заасантай нийцүүлж ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг Журмын 8.5-д заасан хэлбэр, шаардлагын дагуу дахин мэдээлнэ.

8.11. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 5 хоногт багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

8.12. Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид мэдээлэх үүрэг хүлээнэ.

8.13. Хурлын тухай зар мэдээнд дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:

8.13.1. Компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар;

8.13.2. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

8.13.3. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;

8.13.4. Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг;

8.13.5. Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь;

8.13.6. Компанийн дүрэмд заасан болон хурал зарлагч этгээдээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

8.14. Санал авах хуудсаар саналыг урьдчилан авах тохиолдолд санал авах хуудсыг хүлээн авах газар, сүүлчийн хугацааг тусгайлан мэдээлнэ.

8.15. Хувьцаа эзэмшигчдийн эзлжит хурал хуралдах үед дараах бичиг баримтыг танилцуулна:

8.15.1. Компанийн санхүүгийн жилийн тайлан;

8.15.2. Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудиторын дүгнэлт;

8.15.3. Санхүүгийн тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий хэлцлүүд, тэдгээр нь энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу хийгдсэн тухай аудиторын дүгнэлт;

8.15.4. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга;

8.15.5. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо;

8.15.6. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин урамшуулал;

8.15.7. Бизнесийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө;

8.15.8. Хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчийн зайлшгүй мэдэх шаардлагатай бусад мэдээлэл;

8.16. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурал хийх тухай мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдийг 8.15-д заасан баримт бичигтэй танилцах боломжоор хангана.

8.17. Хурлын зар хүргэх үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-г баримтална.

## **ЕС. ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛД САНАЛ ОРУУЛАХ**

9.1. Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон Төлөөлөн удирдах зөвлөл, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл Гүйцэтгэх удирдлагад гаргаж болно.

9.2. Гүйцэтгэх удирдлага нь 9.1-д заасны дагуу ирүүлсэн саналыг Төлөөлөн удирдах зөвлөлд ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.

9.3. Журмын 9.1-д заасны дагуу хувьцаа эзэмшигч саналаа бичгээр гаргах бөгөөд түүнд гаргаж байгаа санал, түүний шалтгаан, санал оруулж байгаа хувьцаа эзэмшигчдийн овог, нэр, түүний эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоог тусгана. Хэрэв Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлж байвал нэр дэвшигчийн овог, нэр /хэрэв компанийн хувьцаа эзэмшигчдийн бол эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо/, дэвшүүлж байгаа хувьцаа эзэмшигчдийн овог, нэр, эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоог тусгасан мэдэгдлийг бичгээр гаргана. Уг мэдэгдэлд нэр дэвшүүлж байгаа шалтгаанаа зааж болно.

9.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь гаргасан нэмэлт саналыг дор дурдсанаас бусад тохиолдолд хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад уг саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор багтаан оруулах үүрэг хүлээнэ:

9.4.1. Санал гаргагч нь Журмын 9.1.-д заасан болзлыг хангаагүй;

9.4.2. Журмын 9.3.-т заасан мэдээллийг бүрэн тусгаагүй.

9.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь нэмэлт саналыг ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор санал гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.

9.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхдээ хараат бус гишүүн, ердийн гишүүний аль нь болохыг заах бөгөөд хараат бус гишүүнд нэр дэвшүүлж байгаа бол компанийн тухай хуулиар тогтоосон шалгуурыг хангах ба шалгуурыг хангаж байгааг нотолсон байна.

9.7. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын тоод өөрчлөлт оруулахыг хориглоно.

## **АРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС**

10.1. Компанийн тухай хуулийн 60.1-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргасан этгээд хурлын тооллогын комиссыг томилох бөгөөд уг комиссын үүргийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр тогтоож болно.

10.2. Хувьцаа эзэмшигчдийн хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн албан тушаалтан болон эдгээр хүмүүстэй нэгдмэл сонирхолтой этгээдийг хурлын тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно.



10.3. Хурлын тооллогын комисс дараах үүрэг хүлээнэ:

10.3.1. Хурлын ирц /кворум/-ыг тогтоож хурлын даргад мэдээлэх;

10.3.2. Тухайн хурлын хэлэлцэх асуудал бүрээр оролцогч этгээд бүрийн саналын эрхийн хэмжээг тогтоох;

10.3.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах асуудалд тайлбар өгөх;

10.3.4. Санал өгөх журмыг тайлбарлах;

10.3.5. Санал өгөх журам болон хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;

10.3.6. Санал хураалтыг санал авах хуудсаар явуулж байгаа тохиолдолд санал авах хуудсыг тоолж, хүлээн авах;

10.3.7. Санал хураалтын дүнг тоолж энэ тухай тэмдэглэл хөтлөх;

10.3.8. Санал тоолж, санал хураалтын дүнг нэгтгэж, дүнгийн тухай шийдвэр гарган тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хуралд танилцуулах;

10.3.9. Санал авах хуудсыг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэх.

10.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнгийн үнэн зөвийг хариуцна.

10.5. Төлөөлөн удирдах зөвлөлөөс хурлын тооллогын комисст хурал хийхтэй холбогдсон бусад үүргийг хариуцуулж болно.

### **АРВАН НЭГ. ХУРАЛД ОРОЛЦОХ ЖУРАМ**

11.1. Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.

11.2. Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн хурал эхлэхээс өмнө төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэнэ. Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хуралд хүчинтэй. Хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй байна.

11.3. Санал авах хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцсонд тооцно.

11.4. Бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд шинэ эзэмшигч этгээдэд хуралд оролцох итгэмжлэл олгох, эсхүл уг шинэ эзэмшигч этгээдийн өгсөн зааврын дагуу санал өгч болно.

### **АРВАН ХОЁР. ХУРЛЫН ИРЦ/КВОРУМ/, ХУРАЛ ХУЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

12.1. Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцоноор хурал хүчин төгөлдөр болно.

12.2. Журмын 12.1-д заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг товлон. Хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчилж үл болно.

12.3. Компанийн саналын эрхтэй хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно.

12.4. Журмын 5.1.1- 5.1.6-д заасан асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хүчин төгөлдөр болно.

12.5. Хойшлогдсон хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулна. Уг хурал хуралдахаас ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.

12.6. Хойшлогдсон хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.

12.7. Компанийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу хүчин төгөлдөр бус гэж үзсэн хувьцаа эзэмшигчдийн түрүүчийн хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц санал хураалтын дүнд тооцно.

12.8. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал журмын 12.5-д заасан хугацаанд хуралдаж чадаагүй тохиолдолд шинээр хурал зарлах бөгөөд ирц /кворум/-ийг журмын 12.1-д зааснаар тогтооно.

### **АРВАН ГУРАВ. САНАЛЫН ХУУДАС**

13.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар өгөх саналыг санал авах хуудсаар авна.

13.2. Хувьцаа эзэмшигчид хурлын шийдвэрт өгөх саналаа санал авах хуудсанд тэмдэглэн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисст ирүүлнэ.

13.3. Санал авах хуудасны агуулга, загварыг хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарласан этгээд батална. Санал авах хуудсанд дараах зүйлийг тусгана:

13.3.1. Компанийн оноосон нэр;

13.3.2. Хурал хуралдах газар, өдөр, цаг;

13.3.3. Хувьцаа эзэмшигчдийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо;

13.3.4. Санал хураалтаар шийдвэрлэх асуудлын томъёолол, төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчийн овог нэр;

13.3.5. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийг сонгоход хэрэглэх санал хураах аргын нэр /ердийн, кумулятив/;

13.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгуульд ердийн журмаар саналаа өгөхөд асуудал бүрээр "зөвшөөрсөн", "татгалзсан" аль нь болохыг тэмдэглэсэн саналын хуудсыг, сонгуульд кумулятив аргаар санал өгөхөд уг аргын тухай тайлбар бүхий тухайн нэр дэвшигчид өгөх саналын тоог тус тус тэмдэглэсэн саналын хуудсыг хэрэглэнэ.

## **АРВАН ДӨРӨВ. САНАЛ АВАХ ХУУДСЫГ ХҮЧИНТЭЙД ТООЦОХ**

14.1. Санал авах хуудсаар өгсөн саналыг дараах тохиолдолд хүчинтэйд тооцно:

- 14.1.1. Ердийн журмаар санал өгөх асуудалд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн;
- 14.1.2. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийг ердийн журмаар санал хурааж сонгох тохиолдолд нэр дэвшигчийн төлөө өгсөн зөвшөөрсөн санал нь сонгогдох гишүүдийн тооноос илүүгүй байх;
- 14.1.3. Нэр дэвшигчийн төлөө өгөх саналаа кумулятив аргаар санал хурааж сонгох тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшигч бүрд өгсөн саналын тооны нийлбэр нь тухайн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тооны нийт дүнгээс илүүгүй байх бөгөөд саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.
- 14.1.4. Төлөөлөн удирдах зөвлөл болон бусад удирдлагын байгууллагын гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг нь тэмдэглэсэн байна.

## **АРВАН ТАВ. ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ШИЙДВЭР ГАРГАХ**

15.1. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг санал авах хуудсыг ашиглан явуулна.

15.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж үл болно.

15.3. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэрт дараах зүйлийг тусгана:

- 15.3.1. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлууд;
- 15.3.2. Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр;
- 15.3.3. Санал авах хуудсыг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх хугацаа;
- 15.3.4. Санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;
- 15.3.5. Санал авах хуудасны агуулга болон загвар;
- 15.3.6. Эчнээ санал хураалт явуулахтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдэд танилцуулах, бичиг баримтын жагсаалт эдгээртэй танилцах боломж, газар.

15.4. Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг энгийн хуралтай адилаар тодорхойлно.

15.5. Эчнээ санал хураалтын санал авах хуудсыг түүнийг эргүүлж хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдэд тараана.

15.6. Нийт саналын эрхийн 50-иас дээш хувийг эзэмшигчид саналаа ирүүлснээр эчнээ санал хураалтыг хүчинтэйд тооцно. Саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор тухайн асуудлыг шийдвэрлэнэ.

15.7. Эчнээ санал хураалтаар ирүүлсэн саналыг тоолох, дүнг гаргах ажлыг тооллогын комисс зохион байгуулна.

15.8. Тооллогын комисс нь санал авах хуудсыг хүлээн авсан сүүлчийн өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор эчнээ санал хураалтын дүнгийн тухай тайлан гаргаж, тооллогын комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж, төлөөлөн удирдах зөвлөлд хүлээлгэн өгнө.

15.9. Эчнээ санал хураалтын дүнгийн тухай тайланд дараах зүйлийг тусгана:

15.9.1. Санал авах хуудсыг хувьцаа эзэмшигчдэд тараасан өдөр;

15.9.2. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлууд;

15.9.3. Санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт, эзэмшиж байгаа хувьцааны тоо;

15.9.4. Шийдвэрлэх асуудал бүрээр саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын нийт тоо;

15.9.5. Эчнээ санал хураалтын дүн;

15.9.6. Эчнээ санал хураалтаар гаргасан шийдвэр.

15.10. Тооллогын комиссын тайланг үндэслэн гаргасан шийдвэрийг тайлан хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчид мэдээлнэ.

15.11. Хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-г баримтална.

#### **АРВАН ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

16.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, хурлын дарга гарын үсгээ зурна. Хурлын тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.

16.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл дараах мэдээллийг агуулсан байна:

16.2.1. Хурал болсон газар, он, сар, өдөр, цаг;

16.2.2. Хурлын даргын овог, нэр;

16.2.3. Хурлаар хэлэлцсэн асуудлууд;

16.2.4. Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо, хурлын ирц;

16.2.5. Санал авах хуудас хэрэглэсэн бол уг хуудасны загвар;

16.2.6. Хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан саналын тоо, гарсан шийдвэрийн бүрэн томъёолол.

16.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд алдаа гарсан нь уг хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

16.4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын болон эцнээ санал хураалтаар гарсан шийдвэрийг тухайн хурал дээр, эсхүл хурал дууссаны дараа санал хураалтын дүн, гарсан шийдвэрийг хүргүүлэх замаар мэдэгдэнэ.

16.5. Хурлын тэмдэглэл нь бичгээр үйлдэгдсэн байх бөгөөд түүнийг баталгаажуулж бичлэг хийж хувийг компанийн архивд хадгална.

16.6. Компани нь хурлын шийдвэрийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.8 болон 56.1.6-д заасны дагуу нэн даруй нийтэд мэдээлж, дараах холбогдох баримт бичиг, мэдээллийг хуульд заасан хугацаа буюу хурал хуралдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ. Үүнд:

16.6.1. ирцийн бүртгэл, итгэмжлэлээр оролцож буй этгээдийн бүртгэл, ирцийн баталгаажилт;

16.6.2. саналын хуудасны хуулбарууд;

16.6.3. тооллогын комиссын дарга, гишүүдийг томилсон шийдвэр;

16.6.4. тооллогын комиссын дарга, гишүүдийн анкет;

16.6.5. тооллогын комиссын шийдвэрүүд;

16.6.6. хурлын тэмдэглэл, хурлын шийдвэрүүд;

16.6.7. шаардлагатай бусад баримтууд.